



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.30 № 01/59/
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд

оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР


2024 он

Цэнгэл

Өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дээдэлсэн, иргэд нь эрх тэгш, элбэг хангалуун, хариуцлагатай байхыг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож, Тосонцэнгэл сумын АРДЧИЛСАН НАМ 2024-2028 оны "ӨРХИЙГ ДЭМЖСЭН-ӨСӨЛТИЙН БОДЛОГО" мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН, БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ

- Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж, шаардлагатай эм тариаг малын хөлийн татвараас зохицуулах системийг бий болгоно.
- Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд малын төрөл, хоорондын харьцаа, сүргийн зохист бүтцийг бүрдүүлэх, орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон, шилмэл үүлдэр, омог, хэвшлийн малыг бататган сайжруулж, өсгөн үржүүлэх зэрэг үйл ажиллагаанд чиглэсэн урамшуулал, эдийн засгийн хөшүүргийг бий болгож өвс тэжээлийн нөөцийг тогтмол бүрдүүлнэ.
- Бэлчээрийн малын ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор малын үүлдэр угсааг сайжруулах, бордох, эрүүлжүүлэх тогтолцоог малчны бүлэг, хоршоонд тулгуурлан зохион байгуулж хамтын ажиллагааг сайжруулж ажиллана.
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар мал сүргийн эрүүл мэндийг хамгаалж, эрүүл, аюулгүй хүнс, үйлдвэрлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ.
- Суурин газруудад "ТОСОНЦЭНГЭЛД ҮЙЛДВЭРЛЭВ" нэрийн худалдааны сувагтай болно.
- Жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах ажлыг зохион байгуулна.
- Аялал жуулчдад зориулсан, нутгийн өнгө төрхийг шингээсэн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
- Орон нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон, ургамлын аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- Бэлчээр ашиглалтын тухай эрх зүйн орчныг боловсронгуй болгож хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.




00000000001

ЭДИЙН ЗАСАГ

- Баялаг бүтээгчдээ дэмжиж, дундаж давхаргын хуримтлалыг дэмжиж нэмэгдүүлнэ.
- Бизнес эрхлэгчдийг мэдээллээр хангаж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх төрийн үйлчилгээг нэвтрүүлж, хувийн хэвшлийнхэнд бизнесийн оновчтой шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлнэ.
- Иргэдийн зах зээлийг хамгаалах үүднээс жижиг дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- Жижиг дунд бизнес эрхлэгчид болон гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтарч ажиллана.
- Эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд, олон талаар дэмжиж ажиллана.
- Гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжиж ажиллана.

ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ЭРҮҮЛ МЭНД

- Нийгмийн хамгааллын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд нээлттэй мэдээллийн сан санаачилж, нийгмийн хариуцлага, сайн сайхны үйлсийг түгээн дэлгэрүүлж, дэмжиж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг алдаршуулах ажлыг зохион байгуулна.
- Эрүүл мэндийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах тал дээр бодлого барьж ажиллана
- Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, стандарт, эмийн зүй бус хэрэглээ, худалдаанд тавих хяналтыг сайжруулна.
- Цэцэрлэг, сургуулийн багш болон эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, хяналтын болон хамтран ажиллах дүрэм, арга зүйн зөвлөмжийг хэрэгжүүлнэ
- Сургууль, цэцэрлэгийн ундны ус, ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагын дагуу шинэчлэн, хүүхдийн ая тухтай сурч, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- Мэдээллийн технологийг сургалтын орчинд өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлж, харилцан мэдээлэл туршлага, солилцдог, өөрсдийгөө хөгжүүлдэг мэдээллийн цахим сүлжээ ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог дэмжинэ. Байгаль орчны салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглахад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.




0000000002

- Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, “ХОВОР АН АМЬТНЫГ ӨСГӨН ҮРЖҮҮЛЭХ” бодлогыг баримталж идэвхтэй ажиллаж байгаа ойн нөхөрлөлүүдийг дэмжиж, урамшуулж, хамтарч ажиллана.

ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, СОЁЛ

- Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна.
- Эмч, эмнэлгийн ажилтны хөдөлмөрийн бүтээмжийг бодитойгоор үнэлж, урамшуулал олгох тал дээр бодлого барьж ажиллана
- Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд анхаарч ажиллана
- Эрүүл мэндийн даатгал голлосон урьдчилан сэргийлэх болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөх тал дээр бодлого чиглүүлж ажиллана.
- Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, удирдах албан тушаалтныг чөлөөлөх, томилох асуудалд аймаг, сумын төлөөллөөс бүрдсэн “Боловсролын зөвлөл”-ийн саналыг харгалздаг байх эрхзүйн орчныг бүрдүүлэх саналаа ИТХ-д уламжилж шийдвэрлүүлнэ.
- Багш нарын хөдөлмөрийн бүтээмжийг бодитойгоор үнэлж, урамшуулал олгох тал дээр анхаарч ажиллана.
- Хүн ам, албан хаагч, ажилчдын цахим боловсролыг дээшлүүлэхэд дэмжиж ажиллана
- Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох тал дээр хамтарч ажиллана.
- Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгосон, хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн, хувь хүнийг хөгжүүлэх тал дээр бодлого баримтална.
- Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн тоог, 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлж ажиллана
- Мэргэжлийн боловсролын сургуулиудад хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн, нарийн мэргэжлийн ангиудад ороход нь сэтгэл санаа болоод хэрэгтэй зөвлөгөөгөөр дэмжиж, ажлын байраар хангах тал дээр дэмжинэ.



Handwritten signature

0000000003